



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/78

Хархорин сум

Эзэмшил газрын байршил
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.6 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арцот ХХК-ны гаргасан хүсэлтийн дагуу Дэд бүтцийн байгууллагын зориулалтаар эзэмшиж байгаа 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дэнж 4 – 15 тоотод байрлалтай 6209007125 нэгж талбарын дугаартай 391м² газрыг хаяг хэмжээ өөрчлөхгүйгээр $X=335070.36$ $Y=5229793.94$, $X=335054.09$ $Y=5229788.93$, $X=335047.28$ $Y=5229810.9$, $X=335054.92$ $Y=5229813.25$, $X=335063.52$ $Y=5229815.89$ тус координатаар байршлыг өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Арцот ХХК-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга) (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Арцот ХХК)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2021 оны А/03 дугаар захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээг 0000045343 тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  ОДГЭРЭЛ



401100155